

**ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН,
ШИНЖЭЭЧИЙН ЭРХ ОЛГОХ АСУУДЛЫГ МЭРГЭЖЛИЙН ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.26, 10 дугаар зүйлийн 10.1.16, 48 дугаар зүйлийн 48.12, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын 3 дугаар зүйлийн 3.1.11, 3.7.6, 3.7.12 болон 4 дүгээр зүйлийн 4.3.9 дэх хэсэгт заасныг үндэслэн геологи, уул уурхайн салбарын мэргэжилтнүүдэд мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Мэргэшсэн мэргэжилтэн гэж Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.26 дах заалтад дурдсан эрх олгогдсон иргэн, мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрхийг олгох төрийн бус байгууллагын гишүүнийг хэлэх бөгөөд мэргэшсэн, зөвлөх гэсэн шатлал бүхий мэргэшлийн зэрэгтэй байна.

Хоёр. Мэргэжлийн төрийн бус байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх) нь геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын мэргэжлийн төрийн бус байгууллага (“үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн төрийн бус байгууллага” гэх) болон ашигт малтмалын нөөцийн стандартын чиглэлээр олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн төрийн бус байгууллага (“олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн төрийн бус байгууллага” гэх бөгөөд үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн төрийн бус байгууллагатай хамтад нь “төрийн бус байгууллага” гэх)-тай санамж бичиг байгуулна.

2.2. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн төрийн бус байгууллага нь ашигт малтмалын нөөцийн стандартын Олон улсын хороо (CRIRSCO)-д Монгол Улсыг төлөөлөн хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллага болсон байна.

2.3. Төрийн бус байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана:

2.3.1. энэхүү журмын 2.1 дэх хэсэгт тусгасан асуудлыг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн захиргааны төв байгууллагатай санамж бичиг байгуулах;

2.3.2. үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн төрийн бус байгууллага нь үндэсний хэмжээнд, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн төрийн бус байгууллага нь ашигт малтмалын нөөцийн стандартын чиглэлээр олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд мэргэшсэн мэргэжилтэн сургах, эрх олгох асуудлыг хэрэгжүүлэх;

2.3.3. геологи, уул уурхайн чиглэлээр эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг их сургуультай хамтран үндэсний болон ашигт малтмалын нөөцийн стандартын чиглэлээр олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн бэлтгэх, сургах, давтан сургах журмыг боловсруулан батлах, нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх;

2.3.4. эрдэс баялгийг зохистой ашиглахад үндэсний мэргэжилтнүүдийн оролцоог хангаж, хариуцлагыг нэмэгдүүлэх;

2.3.5. геологи, уул уурхайн чиглэлээр олон улсад мөрдөж байгаа заавар, дүрэм, журам, стандартыг мэргэжлийн судлаачдын оролцоотойгоор өөрийн орны онцлогт нийцүүлэн боловсруулах, нэвтрүүлэх, нутагшуулах, хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллах;

2.3.6. геологийн судалгаа, ашигт малтмалын ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайлан, ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлд үнэлэлт, дүгнэлт өгөх мэргэшсэн мэргэжилтэнд шинжээчийн эрх олгох;

2.3.7. мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчдийн мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн дүрмийг энэхүү журамд нийцүүлэн батлах, ёс зүйн асуудлыг хэлэлцэх мэргэшсэн мэргэжилтний хороог байгуулах.

Гурав. Мэргэшсэн мэргэжилтний хороо

3.1. Геологи, уул уурхайн салбарын үндэсний болон олон улсын хэмжээний мэргэшсэн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөр боловсруулах, шалгалт авах, шинжээчийн эрх олгох талаар санал өгөх мэргэшсэн мэргэжилтний хороог дараах журмаар байгуулна:

3.1.1. геологийн салбарын үндэсний хэмжээний мэргэшсэн мэргэжилтний болон ашигт малтмалын нөөцийн стандартын чиглэлээр олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн түвшинд мэргэшсэн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөр боловсруулах, шалгалт авах, шинжээчийн эрх олгох талаар санал өгөх мэргэшсэн мэргэжилтний хороог нийт 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр /төрийн захиргааны төв байгууллагаас 2, тухайн чиглэлийн төрийн бус байгууллагаас 2, геологи, уул уурхайн мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг их сургуулиас 1 төлөөллийг оролцуулан/ байгуулна.

3.1.2. уул уурхайн салбарын үндэсний хэмжээний мэргэшсэн мэргэжилтний мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөр боловсруулах, шалгалт авах, шинжээчийн эрх олгох талаар санал өгөх мэргэшсэн мэргэжилтний хороог нийт 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр /төрийн захиргааны төв байгууллагаас 2, уул уурхайн төрийн бус байгууллагаас 2, геологи, уул уурхайн чиглэлээр эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их сургуулиас 1 төлөөллийг оролцуулан/ байгуулна.

3.2. Мэргэшсэн мэргэжилтний хороо нь нарийн бичгийн даргатай байж болох бөгөөд нарийн бичгийн дарга нь хорооны хуралдаанд санал өгөх эрхгүйгээр оролцож, хорооны дотоод үйл ажиллагааг зохион байгуулна.

Дөрөв. Мэргэшсэн мэргэжилтний олгох сургалт зохион байгуулах, мэргэшсэн мэргэжилтний болон шинжээчийн эрх олгох болон цуцлах

4.1. Үндэсний болон олон улсын хэмжээнд нөөцийн стандартын чиглэлээр итгэмжлэгдсэн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох асуудлыг тухайн чиглэлийн мэргэжлийн холбоод, сургалтын байгууллагуудын шаардлагад нийцүүлэн олгоно.

4.2. Төрийн бус байгууллага нь геологи, уул уурхайн салбарын мэргэшлийн зэрэг, шинжээчийн эрх олгох сургалтыг сургалт явуулах материалаг суурь болон боловсон хүчний чадавхи бүхий геологи, уул уурхайн мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг их сургуультай хамтран зохион байгуулна.

4.3. Энэ журмын 4.2-д заасан сургалтыг Төрийн захиргааны төв байгууллагын баталсан мэргэшлийн зэрэг олгох сургалтын хөтөлбөрийн дагуу төрийн бус байгууллага, мэргэшлийн зэрэг олгох сургалт явуулах чиглэлээр танхимын, эрдэм шинжилгээний хурал, сургалт-семинар болон бусад хэлбэрээр зохион байгуулна.

4.4. Мэргэшлийн зэрэг горилогч нь дараах болзол, шалгуурыг хангасан байна:

4.4.1. геологи, уул уурхайн чиглэлээр их, дээд сургууль төгсөж, дээд боловсрол эзэмшсэн байх;

4.4.2. мэргэшсэн зэрэг горилогч нь бакалаврын боловсрол эзэмшсэнээс хойш тухайн мэргэшлийн чиглэлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;

4.4.3. зөвлөх зэрэг горилогч нь мэргэжлээрээ 15-аас доошгүй жил ажилласан, эсхүл мэргэшсэн зэрэг авснаас хойш 6 жил үр бүтээлтэй ажилласан байх;

4.5. Мэргэшсэн мэргэжилтний хороо нь мэргэшсэн мэргэжилтний эрх олгох шалгалтыг өөрийн баталсан журмын дагуу явуулна.

4.6. Энэ журмын 4.2-т заасан сургалтад хамрагдсан, энэхүү журмын 4.4-д заасан шаардлагыг хангасан, мэргэшсэн мэргэжилтийн хорооноос зохион байгуулсан шалгалтанд 60 болон түүнээс дээш хувийн үнэлгээ авсан зэрэг горилогчид төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилсөний үндсэн дээр төрийн бус байгууллагын гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр мэргэшлийн зэрэг олгож, мэргэжлийн гэрчилгээ, батламж, хувийн тэмдэг олгоно.

4.7. Геологи, уул уурхайн мэргэжлийн чиглэлээр боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн энэ журмын 4.4.2, 4.4.3-д заасан хугацааг харгалзан мэргэшлийн зэрэг олгож болно.

4.8. Геологи, уул уурхайн салбарт 25-аас доошгүй жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан мэргэжилтэнд төрийн захиргааны төв байгууллага болон тухайн чиглэлийн төрийн бус байгууллагын саналыг үндэслэн мэргэшлийн зэрэг олгож болно.

4.9. Мэргэшсэн мэргэжилтэнд олгох мэргэжлийн гэрчилгээ, батламж, хувийн тэмдгийн загварыг төрийн бус байгууллага нь төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

4.10. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд мэргэшлийн зэргийг төрийн бус байгууллагын ёс зүй ба гомдол хэлэлцэх хороо, мэргэшсэн мэргэжилтний хороогоор хэлэлцэж, ийнхүү хэлэлцэхдээ Эрдэс баялгийн мэргэжлийн

зөвлөлийн хурлын тэмдэглэл, төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн тухайн мэргэжилтэнд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр цуцална.

Тав. Шинжээчийн эрх олгох, шинжээчид тавигдах шаардлага

5.1. Мэргэшсэн мэргэжилтний бичгээр уламжилсан хүсэлт, энэ журмын 4.5 дахь зүйлд заасан шаардлагыг хангасан тохиолдолд Төрийн захиргааны төв байгууллага нь тухайн эрх олгох Төрийн бус байгууллагатай хамтран шинжээчийн эрх олгоно.

5.2. Ашигт малтмалын тухай хуулийн 48.4-т заасны дагуу ордын нөөц, эрэл, хайгуулын үр дүнгийн тайлан, орд ашиглах болон боловсруулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс энэ журмын 5.1 дэх хэсэгт заасан шинжээчийг томилж ажиллуулна.

5.3. Шинжээчийн эрх олгогдсон мэргэшсэн мэргэжилтний нэрс ил тод байна.

5.4. Геологийн судалгааны тайланд дүгнэлт гаргах шүүмжлэгч шинжээч нь тухайн тайлан зааврын дагуу зохиогдсон эсэх, тухайн дүүрэгт тархсан интрузив бүрдэл, давхарга зүйд хамрагдах хурдас чулуулгийг гарал үүсэл, насны ангиллаар нь ангилсан үндэслэл, талбайн шлих, геохимийн зэрэг сорьцлолтын аргачлал, үр дүнг боловсруулсан байдал, талбайн металлогений үнэлгээ, геофизикийн судалгааны ажлын аргачлал, үр дүнг боловсруулсан байдал, геологийн зураг, тэдгээрийн таних тэмдэгийг зохих зааврын дагуу хийсэн байдал зэргийг нягтлан, дүгнэлт, зөвлөмж өгсөн байна.

5.5. Ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт гаргах шинжээч ашигт малтмалын хүдрийг олборлох ил, далд уурхай барих, хүдэр олборлох, баяжуулах, цэвэршүүлэх технологийн болон үйлдвэрлэлийн машин, техник тоног төхөөрөмжийн сонголт, хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр ашгийн тооцоо, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх тооцоо, судалгаа зэрэгт дүгнэлт гаргана.

5.6. Геологи хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, ашигт малтмалын нөөцийн тооцоотой тайланд дүгнэлт гаргах шинжээч нь ашигт малтмал, газрын тосны хайгуулын ажлын бүхий л аргачлал оновчтой эсэх, нөөцийн тооцооны үндсэн үзүүлэлтүүд үндэслэлтэй эсэх, холбогдох хэмжилт, лабораторын шинжилгээ оновчтой, итгэмжлэгдсэн эсэх, тооцооны материал, зураг, зүсэлт бүрэн, бодитой байгаа, гидрогеологи, хүдэр боловсруулах технологийг судалсан байдал зэрэг нь зохих аргачлалын дагуу хийгдсэн эсэх, техник, эдийн засгийн урьдчилсан үнэлгээний агуулга, түүнд тавигдах шаардлагын дагуу тайлан зохиогдсон эсэхэд дүгнэлт, зөвлөмж өгнө.

Зургаа. Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн ёс зүйн ерөнхий зарчим

6.1. Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч нь мэргэжлийн ажил, үйлчилгээ үзүүлэн шинжээчээр ажиллахдаа шударга ёс, бодит байдал, мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар, хянамгай байх, хараат бус байдал, мэдээллийн нууцыг хадгалах, техник, арга зүйн стандартуудыг баримтлах, мэргэжлийн нэр хүндийг дээдлэх зэрэг зарчим баримтална.

6.2. Мэргэшсэн, зөвлөх мэргэжилтэн нь зөвхөн өөрт олгогдсон мэргэшлийн чиглэлээр аливаа ажил, үйлчилгээ, шинжээчээр ажиллах бөгөөд хэрэв өөр чиглэлээр

дээр дурдагдсан аливаа үйл ажиллагаа явуулсан бол сануулж, анхааруулах бөгөөд энэ гурав болон түүнээс дээш удаа зөрчсөн тохиолдолд эрхийг цуцлана. Ийнхүү цуцлах тохиолдолд энэхүү журмын 4.10 дахь хэсэгт заасан журмыг баримтална.

Долоо. Хэрэгжилтэд тавих хяналт

7.1. Мэргэжлийн төрийн бус байгууллага нь холбогдох нэгдсэн тайлан мэдээллийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.2. Энэхүү журмын дагуу зохион байгуулж байгаа аливаа үйл ажиллагаанд төрийн захиргааны төв байгууллага хяналт, шалгалт хийж, энэхүү журмаар тогтоосон аливаа зүйлийг удаа зөрчсөн болох нь хяналт, шалгалтын явцад илэрвэл тухайн төрийн бус байгууллагатай санамж бичгийг нэг талын санаачилгаар цуцална.

Найм. Журмыг дагаж мөрдөх

8.1. Энэхүү журам батлагдсан өдрөөс өмнө олгогдсон геологи, уул уурхайн мэргэшсэн, зөвлөх инженерийн зэргийг хүчинтэйд тооцож, энэхүү журмын дагуу шинэчлэн бүртгэнэ.

--- оОо ---